



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Монголын хүүхдийн спортын зуны
VII наадмын нэгдсэн зааварт
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.2 дугаар заалт, Засгийн газрын 2021 оны “Спортын наадам хойшлуулах тухай” 268 дугаар тогтоол, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны А/254 дугаар тушаал, Даргын зөвлөлийн 2023 оны 1 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хүүхдийн спортын зуны VII наадам”-ын нэгдсэн зааварт нэмэлт өөрчлөлт оруулсныг хавсралтаар баталсугай.

2. Спортын наадмын нэгдсэн зааварт өөрчлөлт орсонтой холбогдуулан спортын хөтөлбөрт багтсан төрлүүдийн насны ангилал, жин зай, тэмцээний зохион байгуулалтад зохицуулалтыг ханган тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэрэгжилтийн хэлтсийн дарга (Б.Нямсүрэн)-д даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142310079

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны 02 дугаар сарын 03-ий өдрийн А/19 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН ЗУНЫ VII НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 17 дугаар зүйлийн 17.2 дах хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дах заалт Засгийн газрын 2021 оны “Спортын наадам хойшлуулах тухай” 268 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 дахь заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны (цаашид БТСУХ гэх) даргын 2022 оны А/209 дугаар тушаалын 2 дахь заалтыг хэрэгжилтийг хангах, хүүхдийн спортын хөгжлийг эрчимжүүлэх, өсвөр үеийнхний бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, зохион байгуулагдаж буй арга хэмжээг нэмэгдүүлэх, түүний чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, зуны спортын төрлүүдийн авьяаслаг тамирчдыг нээн илрүүлэх, тэдний ур чадварыг дээшлүүлэн, багш, дасгалжуулагчдыг дэмжих, тив, дэлхийн тэмцээнд өрсөлдөх тамирчдыг төрүүлэн гаргахад Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын (цаашид Наадам гэх) зорилго оршино.

Наадмын зорилтыг дараах хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.1. Өсвөрийн тамирчдад спортын ажил, үйлчилгээ үзүүлэх замаар дасгал хөдөлгөөн, спортоор бие даан хичээллэх сонирхлыг төрүүлэх, нийгэмд эерэг манлайллыг бий болгох,
- 1.2. Хүүхдэд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, тэдний харьцаа хандлага, ёс зүй, соёл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, чөлөөт цагийг спортоор хичээллэн зөв боловсон өнгөрүүлэх, дадал, төлөвшлийг бий болгох;
- 1.3. Хүүхдийн дунд зохиох бие бялдрын хүмүүжлийн ажил, спортын үйл ажиллагааг дэмжих, сургалт дасгалжуулалтын чанар, үр дүнг нэмэгдүүлэх, өсвөрийн тамирчдын өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх,
- 1.4. Олимпизмын үзэл санааг дэлгэрүүлэх, олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд өрсөлдөх өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэх, төрүүлэн гаргах,
- 1.5. Спортын тэмцээний зохион байгуулалт, менежментийг чанарын өндөр түвшинд гаргах, орон нутагт биеийн тамир, спортын хөдөлгөөнийг өрнүүлэх.

ХОЁР. НААДМЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Улсын хэмжээнд наадмын ерөнхий зохицуулалтыг Засгийн газрын тохируулагч агентлаг- Биеийн тамир, спортын улсын хороо ханган, наадмын зааврыг сахиулан хэрэгжүүлнэ. Наадмыг зохион байгуулж буй Баянхонгор

аймагтай гэрээний дагуу хамтран ажиллах, санхүү, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

2.2. Баянхонгор аймаг нь наадмын ерөнхий зохион байгуулалтыг хариуцах ба Зохион байгуулах хороо байгуулан ажиллана. Хорооны бүрэлдэхүүнд БТСУХ, ЗГХАгентлаг - Боловсролын ерөнхий газар, Монголын үндэсний олимпын хороо, хүүхдийн спортын холбоо, спортын холбоо, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын төлөөллийг заавал оруулна.

2.3. Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн тэмцээнийг наадмын зохион байгуулах хороо, олон улсын спортын холбоодын гишүүнчлэлтэй спортын үндэсний холбоодтой хамтран зохион байгуулна.

2.4. Наадамд аймаг, дүүргийн Засаг дарга, Биеийн тамир, спортын газар, хороод, Ерөнхий боловсролын сургуулийн захиргаа нь баг тамирчдаа бэлтгэн оролцуулах ба удирдлагаар хангана.

2.5. Наадамд аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага, өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулиуд нутаг дэвсгэрт байрлах харьяаллын дагуу оролцоно.

2.6. Наадмын цахим бүртгэл, нэгдсэн байгууллагын дүн, веб хуудастай холбогдох үйл ажиллагааг БТСУХ-ны цахим сангийн бүртгэл болон мэдээллийн технологи хариуцсан нэгж хариуцна.

2.6. Наадмын явцын мэдээ, мэдээллийг зохион байгуулах эрх олгогдсон аймаг, Зохион байгуулах хороо олон нийтэд сурталчлан мэдээлж, түгээнэ.

2.7. Наадмын спортын төрлийн тэмцээнийг олон улсын дүрэм, спортын холбооны тэмцээний журамд нийцүүлэн наадмын нэгдсэн зааварт тусган хэрэгжүүлнэ. Спортын холбоод тусдаа заавар гаргахгүй.

2.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын төрлөөр наадмын зааврыг тусад нь батлан Улаанбаатар хотноо зохион байгуулна.

ГУРАВ. НААДМЫН ҮЕ ШАТ, СПОРТЫН ТӨРӨЛ

3.1. Спортын наадмыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

Нэгдүгээр үе шат:	Сум, дүүрэг, аймгийн анхан шатны тэмцээн
Хоёрдугаар үе шат:	Бүсийн тэмцээн (зөвхөн багийн спортын төрлөөр зохион байгуулна)
Гуравдугаар үе шат	Аймаг, дүүргийн нэг, хоёрдугаар үе шатны тэмцээнээс шигшигдсэн баг, тамирчин наадмын шигшээ тэмцээнд оролцоно.

3.2. Наадмыг зуны спортын төрлүүдээр зохион байгуулна. Үүнд:

3.2.1 Наадам зохион байгуулах эрх олгогдсон аймгаас санал болгосон болон нэмэлтээр оруулсан спортын төрлүүд багтана.

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ХУГАЦАА, СПОРТЫН ТӨРӨЛ

4.1. Наадмыг дараах хугацаанд зохион байгуулна. Үүнд:

Наадмын анхан шатны тэмцээн I үе шат
2023 оны 05 дугаар сарын 20-ноос өмнө зохион байгуулагдсан байна.

Наадмын бүсийн тэмцээн II үе шат

2023 оны 05 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд
(зөвхөн багийн спортын төрлөөр зохион байгуулна)

Наадмын шигшээ тэмцээн:

2023 оны 06 дугаар сарын 19-28 өдрүүдэд болно.

- нээлтийн арга хэмжээ 06 дугаар сарын 19-ны өдөр болно.
- хаалтын арга хэмжээ 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдана.

4.2. СПОРТЫН ТӨРЛҮҮД:

- | | |
|----------------------|----------------------|
| 1. Байт харваа | 9. Сагсан бөмбөг 5x5 |
| 2. Бадминтон | 10. Спортын бүжиг |
| 3. Бокс | 11. Таеквондо |
| 4. Волейбол | 12. Усанд сэлэлт |
| 5. Гандбол | 13. Хөл бөмбөг |
| 6. Жүдо | 14. Хөнгөн атлетик |
| 7. Крикет | 15. Чөлөөт бөх |
| 8. Сагсан бөмбөг 3x3 | 16. Шатар |
| | 17. Ширээний теннис |

Нэмэлт төрлүүд:

- | | |
|-------------------|---------------------------|
| 18. Буудлага | 21. Самбо |
| 19. Даам | 22. Уран сайхны гимнастик |
| 20. Дугуй (уулын) | 23. Хүндийн өргөлт |

4.2.1 СПОРТЫН ТӨРЛҮҮДИЙН ЗАЙ, ЖИН, НАСНЫ АНГИЛАЛ

Д/Д	спортын төрөл	насны ангилал	ангилал			Нийт
			хөвгүүд	охид	баг/хос тоо	
1	Байт харваа	14-17 нас. 2006.01.01- 2009.12.31	ганцаарчилсан 60м	ганцаарчилсан 60м	баг-3 охид, хөвгүүд, холимог хос	5
2	Бадминтон	14-17 нас. 2006.01.01- 2009.12.31	ганцаарчилсан	ганцаарчилсан	холимог хос, баг- 2 охид, хөвгүүд	5
3	Бокс	15-16 нас. 2007.01.01- 2008.12.31	44 кг, 46 кг, 48 кг, 50 кг, 52 кг, 54кг, 57 кг, 60 кг, 63кг, +63 кг	44кг, 46кг, 48кг, 50 кг, 52кг, 54кг, 57 кг, +57кг	жин-1	18
4	Волейбол	15-18 нас 2005.01.01- 2008.12.31	баг	баг	баг-12	2
5	Гандбол	16-17 нас 2006.01.01- 2007.12.31	баг	баг	баг- 12	2

6	Жудо	15-17 нас 2006.01.01- 2008.12.31	50кг, 55кг, 60кг, 66кг, 73кг, 81кг, - 90кг, +90кг,	40кг, 44кг, 48кг, 52кг, 57кг, 63кг, -70кг, +70кг,	жин- 1	16
7	Крикет	15-17 нас 2006.01.01- 2008.12.31	баг	баг	баг- 13	2
8	Сагсан бөмбөг (3x3)	15-17 нас 2006.01.01- 2008.12.31	баг	баг	баг-4	2
9	Сагсан бөмбөг (5x5)	15-17 нас 2006.01.01- 2008.12.31	баг	баг	баг-12	2
10	Бүжгийн спорт	14-15 нас 2008.01.01- 2009.12.31	латин бүжиг	стандарт бүжиг	хосын төрөл	2
11	Таеквондо	15-17 нас. 2006.01.01- 2008.12.31	48кг, 48-55кг, 55- 63кг, 63-73кг, +73кг	44кг, 44-49кг, 49-55кг, 55-63кг, +63кг	жин тус бүр 1	10
12	Усанд сэлэлт	14-16 нас 2007.01.01- 2009.12.31	чөлөөт сэлэлт 50м; 100м; 200м	чөлөөт сэлэлт 50м; 100м; 200м	холимог баг: 4x100м Medley, хөвгүүд 4x100м 4x100м охид	27
			араар даллах- 50м; 100м; 200м	араар даллах 50м; 100м; 200м		
			өврөөр даллах- 50м; 100м; 200м	өврөөр даллах 50м; 100м; 200м		
			эрвээхэй 50м, 100м, 200м	эрвээхэй 50м, 100м, 200м		
13	Хөл бөмбөг	15-16 нас 2007.01.01- 2008.12.31	баг	ҮГҮЙ	баг-20	1
14	Хөнгөн атлетик	15-17 нас 2006.01.01- 2008.12.31	100м, 200м, 400м, 800м, 1500м, 3000м,	100м, 200м, 400м, 800м, 1500м, 3000м,	буухиа 4x100м хөвгүүд буухиа- 4x100м охид,	24
			уртын харайлт	уртын харайлт		
			гурвын харайлт	гурвын харайлт		
			бөөрөнцөг	бөөрөнцөг		
			зээрэнцэг	зээрэнцэг		
			кросс 5 км	кросс 3 км		
15	Чөлөөт бөх	15-17 нас. 2006.01.01- 2008.12.31	45кг, 48кг, 51кг, 55кг, 60кг, 65кг, 71кг, 80кг, 92кг, 110кг	40кг, 43кг, 46кг, 49кг, 53кг, 57кг, 61кг, 65кг, 69кг, 73кг	жин тус бүр 1	20
16	Шатар	11-12 нас 2011.01.01- 2012.12.31	ганцаарчилсан	ганцаарчилсан	-	2

17	Ширээний теннис	13-17 нас. 2006.01.01- 2010.12.31	ганцаарчилсан	ганцаарчилсан	холимог хос, баг-3	5
Нэмэлтээр						-
18	Буудлага	13-17 нас. 2006.01.01- 2010.12.31	10м хийн урт буу, гар буу	10м хийн урт буу, гар буу	холимог хос	6
19	Даам	14-16 2007.01.01- 2009.12.31	ганцаарчилсан	ганцаарчилсан		2
20	Дугуй (уулын)	14-16 нас 2007.01.01- 2009.12.31	кросс контри: 18км, марфон: 30км	кросс контри: 15км, марфон: 25км	хөвгүүд 2, охид 1,	4
21	Уран сайхны гимнастик	11-15 нас. 2008.01.01- 2012.12.31	-	ганцаарчилсан	баг-5	2
22	Самбо	15-17 нас. 2006.01.01- 2008.12.31	46кг, 49 кг, 53кг, 58кг, 64 кг, 71кг, 79кг, -88 кг, +88 кг	41кг, 44кг, 47кг, 50кг, 54кг, 59кг, 65кг, -72кг, +72кг	жин тус бүр 1	18
23	Хүндийн өргөлт	12-17 нас. 2006.01.01- 2011.12.31	45кг, 49кг, 55кг, 61кг, 67кг, 73кг, 81кг, 89кг, -96кг, +96,	40кг, 45кг, 49кг, 55кг, 59кг, 64кг, 71кг, 76кг, -81кг, +81кг,	баг 10	20

4.3. Техникийн зөвлөгөөн: Тэмцээн зохион байгуулах хороо болон БТСУХ нь нэгдсэн зөвлөгөөнийг хийх ба Зохион байгуулах хороо ба спортын холбооны шүүгчийн зөвлөл нь тэмцээн болох газарт нь тухайн тэмцээний техникийн зөвлөгөөнийг зарлан хуралдуулж, зохион байгуулна.

4.4. Тэмцээний хуваарийн дагуу зохион байгуулагдах техникийн үзүүлэлт, спортын хэрэглэл, зохион байгуулалтыг техникийн зөвлөгөөн дээр ангилал тус бүр дээр хэлэлцэнэ. Техникийн зөвлөгөөнийг тэмцээн зохион байгуулагч төрлийн спортын холбоод зохион байгуулна.

4.5. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороо нь анхан шатны тэмцээнээ зохион байгуулж, тамирчдаа сонгон шалгаруулсан байна.

ТАВ. ОРОЛЦОГЧДОД ТАВИХ ШААРДЛАГА, ОРОЛЦОХ ЖУРАМ

5.1. Наадамд оролцогч тамирчин нь нэг оролцогч-нэг бүртгэл шаардлагыг хангасан байна.

5.2. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороо нь өөрсдийн тамирчдын тэмцээнд оролцох бүхий л бэлтгэлийг хангах ажлыг хариуцна.

5.3. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь тамирчны сурч байгаа өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, хичээллэж байгаа

клубийн нэрийг хамтатган харьяаллын өмнөөс давхардал үүсгэхгүйгээр спортын нэг төрлөө сонгон оролцуулна.

5.4. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороо нь тамирчны цахим гэрээ, мэдүүлгийн маягт илгээхээс өмнө үндсэн байгууллагын удирдлага, дасгалжуулагч нартай харилцан зөвшилцөлд хүрсний дагуу дурдсан хугацаанд хүсэлтээ илгээнэ.

5.5. Бүсийн тэмцээнийг багийн спортын төрлөөр зохион байгуулах бөгөөд нийслэлийн бүсээс 4, баруун, зүүн, хангай, төвийн бүсээс 3 баг тус бүр шалгарч шигшээ тэмцээнд 16 баг оролцоно.

5.6. Наадамд оролцох багууд нь бэлтгэлийн хувцас, спортын төрлийн тоглолтын хувцас, байгууллагын нэр, логотой туг далбааг барьж жагсана. Тугийн хэмжээ нь 60 см х120 см хэмжээтэй байна.

ЗУРГАА. ЭМНЭЛЭГ ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ДААТГАЛ

6.1. Наадамд оролцогч байгууллага өөрийн нэрийн өмнөөс оролцох баг тамирчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, үзлэгийн “зөвшөөрсөн” тэмдэглэгээг эмчийн гарын үсэг, тамгаар баталгаажуулсан байна.

6.2. Тамирчдыг тэмцээний өдрүүдэд дэх гэнэтийн ослын болон бусад холбогдох даатгалд харьяалах байгууллагын зүгээс зайлшгүй хамруулж даатгуулах үүрэг хүлээнэ.

6.3. Аюулгүй байдлыг хамгаалах хэрэглэл, хэрэгслийг тэмцээнд оролцох тамирчдад стандартын дагуу (зориулалтаар хэрэглэхийг тамирчин, хариуцсан дасгалжуулагч, багийн ахлагчаас дүрмийн дагуу шаардана.

6.4. Тэмцээн зохион байгуулагчийн аюулгүй ажиллагаа:

6.4.1. Наадам зохион байгуулах хороо, спортын холбоодтой хамтран тэмцээний үеийн болон бие халаалт, бэлтгэл сургуулилт, үзэгчдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан зам талбайг олон улсын дүрмийн шаардлагын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.

6.4.2. Шүүгч болон тэмцээн зохион байгуулагч шүүгчийн зөвлөлөөс талбайн зохион байгуулалтын дагуу шаардлага тавих, шаардлагыг биелүүлээгүй дасгалжуулагч, тамирчинд холбогдох дүрмийн дагуу шаардлага тавих, хариуцлага хүлээлгэх.

6.4.3. Ковид-19 халдварт цар тахлын цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч УОК, АОК-оос өгсөн заавар зөвлөмжийг дагаж мөрдүүлнэ.

ДОЛОО. ЦАХИМ БҮРТГЭЛ, ЯВАГДАХ ХУГАЦАА, МАНДАТ ОЛГОЛТ

7.1. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөл, ангилал, зайд тамирчныг оролцуулахдаа тусгайлан бэлтгэсэн холбоосоор нэвтэрч тамирчны регистрийн дугаар, хувь хүний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч цахим гэрээ, мэдүүлэг бөглөн илгээнэ.

7.2. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороо нь тамирчны суралцдаг ерөнхий боловсролын сургуулийн хаягийн байршлын дагуу сонгон 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 03 дугаар сарын 16-ны өдрүүдэд

суралцагч сургуулийнхаа Засаг захиргааны нэгж дэх Биеийн тамир, спортын газар, хороонд илгээнэ.

7.3. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод анхан шатны тэмцээнд оролцох өөрийн тамирчдаа www.sport.gov.mn цахим мэдээллийн сангийн тэмцээн, наадмын системийн бүртгэлд бүртгэн анхан шатны тэмцээний үр дүн мэдээллийг оруулсан байна.

7.4. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын удирдлага өөрийн цахим мэдээллийн сан тэмцээн, наадмын бүртгэл хариуцсан ажилтныг ажиллуулна.

7.5. Шигшээ тэмцээнд оролцох нэрээр ирүүлэх мэдүүлэг

7.5.1. Наадмын хөтөлбөрт багтсан тэмцээнд оролцох баг, тамирчдын гэрээ, цахим мэдүүлгийг үндэслэн аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо, ерөнхий боловсролын сургуулийн нэрээр ирүүлэх мэдүүлгийг салбарын нэгдсэн цахим сангийн бүртгэлээр дамжуулан мандатын бүртгэл хийнэ.

Шигшээ тэмцээний цахим систем нь 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр нээж 2023 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 22:00 цагт хаана.

7.5.2. Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн тэмцээнд оролцох баг, тамирчдын анхан шатны цахим гэрээ, нэрээр ирүүлсэн мэдүүлгийг үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 12:00 цагаас эхлэн шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдын QR кодтой мандатын эх файлыг аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын албаны цахим шуудангийн хаягаар илгээнэ.

7.5.3. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын асуудал хариуцсан нэгжээс тухайн спортын төрлөөр оролцох баг тамирчдын QR кодтой мандатын файлыг засаг захиргааны нэгж дэх спортын наадамд оролцох өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн байгууллагын баг тамирчдад илгээсэн байна.

7.5.4. Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөлд оролцох баг тамирчид наадмын мандатын ажлын хэсэгт тэмцээний хөтөлбөрт заасан техникийн зөвлөгөөнөөс өмнө мандатын баталгаажилтыг хийлгэснээр тэмцээнд оролцох эрх үүснэ.

7.5.5. Цахим бүртгэл хариуцсан аймаг, дүүргийн болон спорт холбоодын (наадамд оролцогч бусад байгууллага) админ нь наадамд оролцох дасгалжуулагч, шүүгч, албаны болон бусад чиг үүрэг гүйцэтгэн оролцох төлөөллийн бүртгэлийг тэмцээн наадмын системийн цахим бүртгэлийн хугацаанд нэгэн адилаар бүртгэж мандат олгоно.

7.6. БТСУХ-ны цахим бүртгэлийн асуудал хариуцсан нэгжээс баталсан цахим бүртгэлийн сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

7.7. БТСУХ-ны цахим бүртгэлийн асуудал хариуцсан нэгж нь Боловсрол шинжлэх ухааны яамны асуудал хариуцсан нэгжээс сурагчийн мэдээллийн сүлжээний оролцоотойгоор нягтлан бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хариуцаж ажиллана. Оролцогчийн шилжилт хөдөлгөөнийг цахим гэрээ, мэдүүлэг илгээсэн өдрөөр тасалбар болгоно.

7.8. Цахим бүртгэлтэй холбоотой мэдээллийг www.sport.gov.mn цахим хуудсанд байршуулна.

НАЙМ. НААДМЫН ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛЫН ЧИГЛЭЛ

Наадмын хүрээнд дараах арга хэмжээг авч явуулна.

- Анхан шатны тэмцээн зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах, зохион байгуулах;
- Наадмын анхан шатны болон шигшээ тэмцээнд оролцох төсвийг батлан гаргах;
- Тухайн нутаг дэвсгэр, байгууллагын өсвөрийн хүүхдийг олноор нь хамруулсан хэлбэрээр нийтийг хамарсан тэмцээн, зуны спортыг сурталчилсан арга хэмжээг зохион байгуулах;
- Зуны спортын хөгжлийн чиглэлээр хурал, семинарыг явуулах, гарын авлага, ном, товхимол гаргах;
- Тухайн нутаг дэвсгэр, байгууллагын хэмжээнд өдөрлөг, спортын арга зохион байгуулах, материаллаг баазаа бэхжүүлэх, хэрэглэл материал худалдан авах, спортын талбай байгуулан, тохижуулах;
- Зуны спортын төрлөөр секц нээн ажиллуулах хөдөлгөөн өрнүүлэх, алдартай тамирчдаа сурталчлах, алдаршуулах, наадмын мэдээллийн байнгын булан гарган ажиллуулах;
- Наадмын шигшээ тэмцээнд амжилтай бэлтгэн, идэвхтэй оролцуулах төрөл бүрийн арга хэмжээ авах;
- Олимпизмын үзэл санааг сурталчлан, олимпын боловсрол олгох үйл ажиллагааг явуулан Засгийн газрын тохируулагч Агентлаг - Биеийн тамир, спортын улсын хороо, Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг - Боловсролын ерөнхий газар, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний олимпын академиас 2023 онд явуулж байгаа болзолт уралдааны үйл ажиллагаанд аймаг, дүүргийн Олимпын зөвлөлүүд болон Ерөнхий боловсролын сургуулиуд дахь олимпын танхимуудаар дамжуулан оролцох.

Эдгээр арга хэмжээг зохион байгуулан, хийсэн бусад ажлын тайлангаа баримтжуулан ЗГТА- БТСУХ-нд ирүүлнэ.

ЕС.НААДМЫН ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ

9.1. Наадмын анхан шатны тэмцээн зохион байгуулах болон шигшээ тэмцээний хөтөлбөрт багтсан тэмцээнд оролцогчдын томилолт, хоол, байр, унааны зардлыг баг тамирчид оролцуулагч харьяалах байгууллага нь хариуцан санхүүжүүлнэ.

9.2. Баг тамирчид наадмын тэмцээнд оролцохдоо эрхийн мандатын үнэ, бусад төлбөрүүд төлөхгүй.

9.3. Наадмын зохион байгуулалтын зардал, шагнал урамшуулал болон бусад шаардагдах зардлыг наадмыг зохион байгуулах эрх хүлээн авч, гэрээ байгуулсан аймгийн Зохион байгуулах хороо хариуцна.

9.4. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын 4.4 дэх заалт “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах жилд тухайн насны ангиллын улсын аварга шалгаруулах тэмцээнийг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй” байх, Эрүүл мэнд, Сангийн сайдын хамтран баталсан 2009 оны 53/45 дугаар тушаалын 2.10 дахь заалт “Спортын наадмын хөтөлбөрт багтсан төрлүүдийн тухайн насны ангиллаар Улсын аварга шалгаруулах тэмцээнийг тухайн жилд

давхцуулан явуулахгүй” гэсэн заалтыг аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар /хороо/-ууд хэрэгжүүлэн ажиллах үүрэгтэй.

АРАВ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Наадмын шигшээ тэмцээний төрөл зай, ангилал тус бүрд эхний гурван байр эзэлсэн баг, тамирчдыг ЗГТА-БТСУХ, наадмын ЗБХ-ноос тус бүрд нь доорх шагналаар шагнаж урамшуулна.

10.1. Тамирчин, дасгалжуулагчийг:

10.1.1. Спортын наадмын тэмцээний төрлийн зай, ангилалд медаль хүртсэн тамирчин, дасгалжуулагчийг Монголын хүүхдийн спортын VII наадмын медаль, өргөмжлөл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу мөнгөн шагнал олгоно.

10.1.2. Тамирчны регистрийн дугаар, нас, овог нэрийг санаатай буюу санамсаргүйгээр буруу бөглөсөн, харьяаллын болон бусад зөрчил илэрсэн тохиолдолд тухайн тэмцээний амжилтыг хүчингүйд тооцон дараагийн эрэмбэлэгдсэн тамирчин, багт эзэлсэн байр, шагналыг шилжүүлнэ.

10.2. Оролцогч байгууллагыг дүгнэх

10.2.1. Наадмын зуны спортын төрлүүдэд авсан медалийн чанараар дүгнэнэ.

10.2.2. Засаг захиргааны нэгжийн аймаг, дүүрэг, ерөнхий боловсролын сургуулиудыг медалийн чанараар эхний 6 байр эзлүүлж цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар Зохион байгуулах хорооноос шагнаж урамшуулна.

- Аймаг, дүүргийн БТСГ-ыг байгууллагын дүнгээр эхний зургаан байр эзлүүлэн цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,

- Ерөнхий боловсролын сургуулийг байгууллагын дүнгээр эхний гурван байр эзлүүлэн цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,

- Ерөнхий боловсролын спортын төрөлжсөн сургалттай сургуулийг байгууллагын дүнгээр 1-3 дугаар байр эзлүүлэн цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,

АРВАН НЭГ.САХИЛГА БАТ, ДЭГ ЖУРАМ

11.1. Спортын үнэт зүйл болох мэндлэх, талархах ёс үйлдлийг баримтална. Спортоор дамжуулж тамирчдад сахилга бат, ёс зүйтэй байх, нийгэмд зөв хандлага, эерэг нөлөөллийг бий болгоно.

11.2. Баг тамирчид наадмын үйл ажиллагаа, тэмцээний зам талбай гараа, бариа тогтсон байршилд, нэгдсэн зохион байгуулалтад орж үүрэг хариуцлага, хувь хүний харилцаа хандлагыг бүрэн ухамсарлаж хариуцна.

11.3. Өрсөлдөгч нараа хүндэтгэн, шударга өрсөлдөөнийг үзүүлнэ.

АРВАН ХОЁР. ХҮСЭЛТ ГОМДОЛ

12.1. Тэмцээнд оролцох баг, тамирчид маргаантай асуудлаар тэмцээний ерөнхий шүүгчид хүсэлт, гомдол гаргах эрхтэй. Наадам зохион байгуулах хороо болон зохион байгуулагч спортын холбооны маргаан таслах зөвлөл шийдвэрлэнэ.

12.2. Хүсэлт, гомдлыг зөвхөн тухайн баг хариуцсан дасгалжуулагч, багийн ахлагч бичгээр өөрийн биеэр тэмцээний ерөнхий шүүгчид багийн нэр хаяг, гарын үсгийг тодорхой бичиж хандана.

12.3. Цахим бүртгэлтэй холбоотой гаргасан хүсэлт, гомдол нь үндэслэлтэй байх шаардлагатай бөгөөд БТСУХ шийднэ.

---oOo---